

**УЛС ТӨРИЙН СЭТГЭЛГЭЭНИЙ ТҮҮХЭН ДЭХ УЛС ТӨРИЙН ХЯМРАЛЫН
ТУХАЙ ҮЗЭЛ САНАА БА ТҮҮНИЙ ХУВЬСАН ӨӨРЧЛӨЛТ****С.Базарпүрэв** доктор, профессор**Г.Туяагэрэл** докторант

Товч утга: Улс төрийн хямралын тухай үзэл санаа бүрэлдэн тогтсон үйл явцыг хэдэн мянган жилээр хэмжих боломжгүй юм. Төр, нийгэм улс төрийн харилцаанд үүсэх хямралын тухай үзэл санаа нь Эртний Грекийн сэтгэгчдээс эхлэлтэй гэж үздэг. Нийгэм-улс төрийн систем дэх хямралын тухай үзэл санааг үеийн судлаачид харилцан адилгүйгээр тодорхойлсон байх ба энэ нь улс төрийн хямралын талаарх орчин үеийн гэж нэрлэгдэж буй онол, үзэл санааны эхлэл болсон юм. Тиймээс орчин үед улс төрийн хямралын тухай онол-үзэл баримтлалын үүсэл ба түүний агуулга хэрхэн хувьсан өөрчлөгдөж байгаа талаар судалгаа шинжилгээний ажил хийгдсээр байна. Улс төрийн хямрал гэх энэ ойлголтыг хэрхэн хувиран өөрчлөгдөж байгааг тодорхойлохын тулд түүхийн үечлэлийн хүрээнд энэ нэр томъёоны утга агуулгыг авч үзэх хэрэгтэй юм. Хүн төрөлхтний түүх нь:

1. Эртний үе- Иргэншил анх үүссэн үеэс Ромын эзэнт гүрний уналт хүртэлх үеийг багтаан авч үзсэн байдаг.
2. Дундад зууны үе- V-XV зуун хүртэл
3. Сэргэн мандалтын үе- XV-XVI зуун хүртэл
4. Шинэ үе-XVII-XIX зуун хүртэл
5. Нэн шинэ үе- (XX-XXI зуун хүртэл) үеэс бүрдэнэ.

Энэ үечлэл дээр тулгуурлан улс төрийн хямралын тухай онол үзэл баримтлал төлөвшсөн цаг хугацааг дараах үндсэн дөрвөн үе шатанд авч үзэж байна. Үүнд:

1. Улс төрийн хямралын тухай анхны үзэл санаа төлөвшсөн эртний үе
2. Дундад зууны болон сэргэн мандалтын үеийн сэтгэгчдийн улс төрийн хямралын тухай үзэл санаа
3. Шинэ үеийн нийгэм-улс төрийн сэтгэгчдийн улс төрийн хямралын тухай үзэл санаа
4. Орчин үеийн сэтгэгчдийн улс төрийн хямралын тухай үзэл санаа гэж үзэж болох юм.

Дээрх цаг хугацааны явцад зөвхөн улс төрийн хямралын тухай үзэл санаа төдийгүй өнөөгийн нийгэм-улс төрийн шинжлэх ухаанд судлагдаж байгаа судлагдахуунуудын талаарх анхны ойлголт үзэл баримтлалууд төлөвшсөн юм. Тиймээс тухайн түүхэн цаг хугацаа гэдэг бол нийгмийн оюун санаа, улс төрийн амьдралд өөрийн гэсэн ул мөрийг үлдээж байдаг гэсэн үг юм.

**Улс төрийн хямралын талаар анхны үзэл санаа
төлөвшсөн эртний үе**

Улс төрийн хямралын тухай үзэл санаа төлөвшсөн цаг хугацааны эхлэл нь хүн төрөлхтний түүхийн эртний үе юм. Улс төрийн хямралын тухай анхны үзэл санааг томъёолох оролдлого нь тухайн үед хүмүүсийн хооронд үүссэн захирах захирагдах харилцааны зөрчлийн учир шалтгааныг таньж мэдэх гэсэн оролдлого нөгөө талаас нэг хэсэг ард түмэн нь аз жаргалтай сайхан амьдарч, төр улс нь

хөгжиж байхад нөгөө нэг хэсэг нь яагаад хөгждөггүйг мэдэхийг хүссэн тэр үеийн сэтгэгчдийн үзэл санаатай холбоотой юм. Эртний Египет, Энэтхэг, Хятад, Перс, Грек, Ромчууд болон бусад улс үндэстэнүүд тухайн үед аливаа зүйлд хандах хандлага нь үлгэр, домог зүйтэй холбоотой байсан. Хүн төрөлхтний хөгжлийн эхэн үед бүрэлдэн тогтсон улс төрийн хямралын тухай үзэл санаа нь өнөөгийн түүнийг тайлбарлах онол үзэл баримтлалаас ялгаатай байсан нь тодорхой юм. Хэдийгээр улс төрийн хямралыг онолын төвшинд ойлгож тайлбарлах хандлагыг тэр үед бий болгоогүй ч дэлхий ертөнцийг таньж мэдэх гэсэн шашин домгийн хандлага нь дан ганц улс төрийн хямралын тухай үзэл санааг бус нийгэм-улс төрийн бүхий л үзэгдэл үйл явцыг тайлбарлах анхны хандлага байсан юм. Тэр үеэс өнөө үед өвлөгдөн ирсэн тэгш ёс, шударга байдал, захирах захирагдах ёсны уламжлал, нийгмийн дэг журам зэрэг улс төрийн уламжлал, ёс зүйн хэм хэмжээ бэлгэдэл зүй, домгийн агуулад байжээ. Эртний Грекийн түүхэн эх сурвалжид ("Поучения Птахотепа"(мэе XVIII), "Книга мертвых (мэе XV-XIV)", "Поучение греклаополского царя своему сыну") "Бурханы тогтоосон шударга ёс" гэдэг бол нийгэм-улс төрийн амьдралын дэг журам юм. Тиймээс хүмүүс хоорондын харилцааг зохицуулах нэг арга хэрэгсэл юм гэж үзжээ. Шударга байх нь зөрчил тэмцэлгүй тайван амьдрахын эх үндэс, шударга байна гэдэг нь бурханы тогтоосон хэм хэмжээнд захирагдан амьдрах явдал" хэмээн тодорхойлсон. Улс төр эрх зүйн анхны бүтээлийн нэгэнд зүй ёсоор ордог мэе XVIII зуунд бүтээгдсэн Хаммурап хааны хуулинд "Улс орныг удирдана гэдэг тэр хүний шилдэг сайных нь биш зүгээр л бурхан тэнгэр ингэж үзсэн болохоор л улс орныг удирдаж байгаа юм" гэж төрийн удирдлагыг бурханчлах тайлбарлах хандлагыг тодорхойлсон байдаг. Хүмүүс өөр хоорондоо харилцан адилгүй эрх эдлэж нэг нь чөлөөтэй иргэний хувиар амьдарч байхад нөгөө нэг хэсэг нь хэн нэгний удирдлагад захирагдан амьдрах нь тэр хүмүүсийн амьдралын оноосон тавилан гэж үзсэн ажээ. "Газар тэнгэрийн их шүүх Хаммурап миний, улс орондоо урьдаас зөгнөн тогтоосон энэхүү шударга ёсыг бүх иргэд олноороо даган мөрдөх учиртай бөгөөд түүнийг хэн ч дур мэдэн өөрчилж болохгүй"¹ гэж тэмдэглэсэн байдаг.

Эртний Персийн шашин-ёсзүйн сургаалийг (зороастризм) үндэслэгч Заратустра буюу Зороастр(мэе VIII)-ын бүтээлд хямрал, хямралт нөхцөл байдлын тухай анхны үзэл санаа тусгалаа олсон байдаг гэж үздэг. Энэ сургаалаараа тэрээр амьдралын сайн муу эсрэг тэсрэг байдлын хоорондын зөрчлийг харуулсан байдаг ба ингэхдээ сайн сайхан байдлыг өөрөөсөө гэрэл гэгээ цацруулсан Ормузда бурханаар хар бараан муу муухай зүйлийг эсрэг талын Ариман бурханаар дүрслэн илэрхийлсэн байдаг. Аливаа хүмүүн төрөлхтөн муу муухай зүйлийн эсрэг тэмцэж амьдардаг гэдгийг дээрх хоёр талын тэмцлээр дүрслэн харуулсан байна. "Төр гэдэг бол дээд тэнгэрт оршин буй Ормузда бурханы газар дээрх биелсэн хэлбэр бөгөөд харин хаан гэдэг бол төр улсад учирч болох муу муухай зүйлийн эсрэг тэмцэгч түүний албат юм"² хэмээн тэмдэглэсэн.

Энэтхэгийн эртний түүхийн эх сурвалжийн нэг болох "Бхагавадгита"-д улс орныг хаанчлан суух нь олон хүчин зүйлээс шалтгаалах ба энэ нь санамсаргүй зүйл биш гэж авч үзсэн байдаг. Аливаа бүтэц шаардлагатай тохиолдолд өөрөө өөрийгөө хадгалан үлдэхийг эрмэлздэг шиг улс орныг удирдаж буй хаан ч гэсэн урт удаан хугацаанд хаанчлалаа тогтоохыг эрмэлздэг талаар уг бүтээлд дурьдсан байна. Мөн улс орны хувьд үүссэн нөхцөл байдал, тухайн улсыг удирдаж байгаа эрх

¹ Рыжов О.А. Политико-правовая мысль: история и современность: Учебно-методическое пособие. М, 2005. с.5-8

² Рыжов О.А. Политико-правовая мысль: история и современность: Учебно-методическое пособие. М, 2005. с.9

мэдэлтнүүдийн зорилгын хооронд үл тохирох байдал үүсч болдог. Улс оронд хямрал үүссэн тохиолдолд түүнийг даван туулах улс төр ёс суртахууны хүчин төгөлдөр дүрэм журамтай байх ёстой гэж үзсэн байдаг.

Улс төрийн сэтгэлгээний түүхийн үнэт өв болох "Артхашастр"(мэе IV-III) хэмээх бүтээл нь улс төрийн хямралын талаар анхны үзэл санааг тусгасан бүтээлийн тоонд зүй ёсоор ордог. Уг шаштирыг Эртний Энэтхэгийн хаан 1-р Чандрагуптын мэргэн зөвлөх Каутилья туурвисан хэмээн үздэг ба тэрээр энэ шаштираараа хүмүүс ядуу амьдарч байгаагийн шалтгааныг эргэцүүлэн бодоод хаан ба ард иргэдийн хоорондын зөрчилдөөнт байдлаар дамжуулан түүнийгээ тайлбарласан байдаг. "Улс орны хувьд тулгарч буй бэрхшээл, өвчин зовлон, өлсгөлөн ядуурал бүгд нь тухайн улсын гадаад, дотоодод нүүрлэж болохуйц хямрал, үймээн самууны шалтгаан юм. Улс орны дотоодын үймээн самуун нь хэр их хор хөнөөлтэй байна тэр хэмжээгээр гадаад үймээн самуун нь сөрөг нөлөөлөл үзүүлдэг. Мөн хаанд ойр шадарладаг түшмэд энэ үймээн самууныг дэгдээсэн бол энэ байдал нь магадгүй хааныг ч түлхэн унагах аюултай байдаг"³

Артхашастраас өмнө бүтээгдсэн эртний шаштируудад улс төрийн засаглалын хямралын шалтгааны нэг нь улс оронд хоёр хаан байх явдал юм үзсэн байдаг. Тухайн үед улс орныг хоёр хаан удирдах нь улс төрийн засаглалын байж болох нэн муу хэлбэрт тооцогддог байжээ. Харилцан бие биендээ дайсагналцсан аль эсхүл бие биенээсээ харьцангуй хамааралтай болсон хоёр хаан улс орныг удирдах нь тухайн төр улс мөхөж үгүй болохын дохио юм гэж үзсэн байдаг. Артхашастрт улс орныг хоёр хаан удирдах нь хэдийгээр ийм сөрөг талтай ч түүний эерэг хэлбэр байж болно гэж дурьдаад хэрвээ албат түшмэд нь талцан хуваагдахгүй бүгд нэгэн зэрэг тэдэнд үйлчилдэг бол эцэг хүү юмуу аль эсхүл ах дүү хоёрын хаанчлал нь улс оронд амар амгалан байдлыг тогтоож чадна гэж үзсэн байдаг. Мөн дээрх бүтээлд улс төрийн засаглалын хямралын бусад шалтгааныг авч үзсэн байдаг ба хаан хүн юуг хийж болох юуг хийх хэрэггүйгээ мэддэг байх нь өөрийн засаглалаа урт удаан хугацаанд ард түмнээрээ хүлээн зөвшөөрүүлэхийн баталгаа юм гэж үзсэн байдаг.

Энэ нь улс төрийн засаглалын хямралын бас нэгэн шалтгаан нь хааны үйл байдал байж болохыг харуулж байгаа юм. Каутилын үзэж байснаар дараахь тохиолдолд улс оронд үймээн самуун, эмх замбараагүй байдал үүсдэг байна. Үүнд:

- "Хааны батлан гаргаж байгаа хууль нь оршин буй бүхний амьдралын зорилготой зөрчилдсөн шинж чанартай байвал
- Хаан хүсэл зоригоо гүйцэлдүүлэх зорилгоор эрх мэдлээ ашиглах, бусдын хүсэл зоригийг үл тоомсорлох
- Хэрвээ хаан эрх мэдлээ зүй зохистой ашиглаж чадаагүйн улмаас ард түмний дүргүйцлийг төрүүлж хаан ба ард түмэн зөрчилдөхөд хүрсэн тохиолдолд
- Хэрвээ хаан ухаан муутай, ховдог шунахай сэтгэлтэй, үрэлгэн зантай бол түүний хаант засаглал ганхахад хүрнэ"⁴

Эртний Шумерчуудын "Царские списки"(мэе III-II) шаштирт улс төрийн засаглалын хямралаас хэрхэн урьдчилан сэргийлэх улмаар түүнээс ангид байх талаар авч үзсэн байдаг. "Эзэн хаанаа "Мэ" гэж нэрлэдэг байсан ба энэ хаан нь Эреду хотод тэнгэрээс бууж өөрийн хаанчлалыг тогтоосон хэмээн бичсэн байдаг. Үүнээс хойш Киш, Урук, Ур, Аккад гэх мэт олон эзэнт гүрнүүд бий болсон байна. Энэ мэтээр нэг

³ Барсамов В.А. Политические кризисы и смуты (история, теория и современность). М, 1996.с.25

⁴ Артхашастр. М. Наука, 1993. с.25

хаанаас нөгөө хаанд улс орныг удирдах эрх шилжихдээ ямар ч үймээн самуун дайсагналцал үүсдэггүй байсан”⁵ талаар дурьдсан байдаг.

Эртний Хятадын сэтгэгчид дэлхий ертөнц дээр оршин тогтнож байсан эзэнт улсуудын сэргэлт ба уналтын шалтгааныг судлан тогтооход анхаарлаа хандуулж байсан байдаг. Кунз өөрийн бүтээлдээ улс орны сэргэлт мөхлийн шалтгаан зүй тогтлын талаар дурьдсан байдаг ба өнөө үед ч судалгаа шинжилгээний ач холбогдлоо алдаагүй байгаа юм. Кунзын нэгэн бүтээлд “Хэрвээ улс орныг удирдаж байгаа хаан болоод түшмэд нь өөрсдөө эвтэй хийгээд дэг журамтай байж чадваас ард түмэн нь тэдэнд бүрнээ захирагдана. Хэрвээ үр хүүхэд нь аав ээждээ ачлалтай байдаг шиг хаад түшмэд нь ард түмэндээ энэрэнгүй сэтгэлээр хандаж чадваас ард түмэн тэдэнд тийм өгөөмөр сэтгэлээр хандах болно. Хэрвээ хаант төр зөвхөн сайн хүмүүсийг төрийн албанд зүтгүүлж тэднийг дахин шүтэж чадах аваас тэр хүмүүс яахан муу зүйл хийх билээ. Тиймээс ард түмэн ч гэсэн хичээнгүй ухаантай байх авай”⁶ гэсэн байдаг.

Улс төрийн хямрал зайлшгүй зүйл болох, үүний төлөө засаглагчид яагаад хариуцлага хүлээх ёстой талаар Кунз бүтээлдээ дурьдахдаа: “Тэнгэрийн дор оршиж буй бүхэнд дэг журам үйлчлэх ёстой. Дэг журам үйлчилж байгаа газар түүнийг зөрчсөн хүмүүст залхаан цээрлэлтийг тэнгэрийн хүү үзүүлж байдаг. Ийм дэг журам байдаггүй газар буруу зүйл хийснийх нь төлөө хүмүүст шийтгэлийг дан ганц удирдагч л өгч байдаг. Ийм улс оронд засаглал нь арван үе дамжин оршин тогтнох нь маш ховор төдийгүй боломжгүй юм. Хэрвээ улс оронд дэг журмыг ноёд, түшмэд тогтоож байвал тухайн хаант засаглал эрх мэдлээ таван үедээ авч үлдэх нь мөн ховор тохиолдол юм. Хэрвээ улс орны хувь заяа нь жижиг ноёд түшмэдийн гарт байх аваас тухайн хаант засаглал эрх мэдлээ гурван үедээ хадгалж үлдэнэ гэдэг бол бүр ч ховор тохиолдол. Тэнгэрийн дор оршин амьдарч буй бүхнийг өөрсдийн сайн дураараа хүлээн авсан дэг журам нь засаглах аваас улс орны удирдлага түшмэдийн гарт байхаа больж харц иргэн ч гэсэн дургүйцэлгүйгээр хаант төрдөө захирагдах болно”⁷

Мэн-зы бүтээлдээ “Хүнлэг энэрэнгүй сэтгэлтэй, ухаантай хүмүүстээ итгэл хүлээлгэдэггүй төр мөхөж үгүй болдог. Хэрвээ захирч байгаа дээд хүмүүс захирагдаж байгаа ард түмний хооронд шударга ёс дэг журам үйлчлэхгүй бол тэр нийгэмд эмх замбараагүй байдал ноёрхдог. Хэрвээ ард түмэн удирдлагаа сайн дураараа хүлээн зөвшөөрөөгүй бол үүнээс өөрөөр түүнийг хүлээн зөвшөөрүүлэх өөр ямар ч арга ач холбогдолгүй байх болно”⁸ гэж тэмдэглэсэн байдаг.

Хятадын эртний нэрт сэтгэгч Гунн Чжун бүтээлдээ улс төрийн хямралын шалтгааныг авч үзээд “Хэрвээ хаант төрийн чухал нууцыг мэддэг түшмэд нь өөрийнхөө зөв гэдэгт ард түмнийг итгүүлэн үнэмшүүлж тэднийг өөрийн талд оруулахын тулд мөн хаант төрийг үймүүлэх зорилгоор далдуур бусад түшмэдтэй үгсэн хуйвалдаж улс оронд эмх замбараагүй байдал үүсгэвэл хаант төрдөө итгэх ард түмний итгэл алдагддаг. Тиймээс язгуур угсаа, гарал үүслээ мартан бусадтай үгсэн хуйвалдах, ард түмний итгэлийг алдах нь хаант төрийн мөхлийн шалтгаан болно”⁹ хэмээн хаант төрийг сүйрэлд хүргэж болох хүчин зүйлийг томъёолсон байдаг. Мөн “Үнэхээр хаант төрийн төлөө байдаг түшмэдийг дэмжихгүй байх нь магадгүй тэднийг хаанаа шүтэн дээдлэх, улмаар түүнд захирагдах хүсэл зоригийг нь

⁵ История политических и правовых учений. Древний мир. М. 1985. с.84-85

⁶ Древнекитайская философия. Т1. М. 1994. с.169-170

⁷ Древнекитайская философия. Т1. М. 1994. с.170-171

⁸ Древнекитайская философия. Т1. М. 1994. с.246

⁹ Древнекитайская философия. Т1. М. 1994. с.2

мохоож бусадтай далдуур хуйвалдах шалтгаан ч болж болох учраас хаан дан ганц ард түмнийг л удирдах захирахын тухай ярихын зэрэгцээ хаант төрд үнэнч ноёд түшмэддээ захирагдаж тэднийг дэмждэг байх хэрэгтэй”¹⁰ талаар авч үзсэн байдаг.

Шан Ян “Книге правителя области Шан” бүтээлдээ улс оронд үймээн самуун дэгдэхэд хүргэдэг хэд хэдэн хүчин зүйлийг авч үзсэн байдаг. Тэрээр “Улс оронд дэг журам байхгүй бол ард түмэн ба хааны хооронд итгэлцэл байхгүй болно. Улмаар ийм хаант төр ард түмнээрээ хүлээн зөвшөөрүүлж чадахгүй байх болно. Улс оронд үйлчилж байгаа хууль дүрэм журам тодорхой биш байвал улс оронд эмх замбараагүй байдал үүснэ. Хаант төр нь мэргэн удирдлага дээр суурилсан бол төрийн бодлого нь хэзээ ч сохор байдаггүй. Ийм улсад хууль нь хэзээ ч нэг хэсэг хүмүүст үйлчилдэггүй. Тиймээс хаант төр ба ард түмэн хоёрыг нэгэн зэрэг холбож чадсан төрийн сайн удирдлага нь үймээн самуун, эмх замбараагүй байдал гаргахгүй байх баталгаа нь болдог”¹¹ хэмээн үзсэн байна.

Орчин үеийн улс төрийн шинжлэх ухаанд улс төрийн хямрал хэмээх энэ судлагдахууныг судалгаа шинжилгээний эргэлтэнд ороход их нөлөөлсөн нэг хүчин зүйл нь эртний Грекийн сэтгэгч Демократын үзэл санаа байсан юм. Тэрээр улс төрийн хямрал болон дайны эх үүсвэр, шалтгааныг зохиол бүтээлдээ дурьдсан байдаг. Демократаас өмнө дайны шалтгааныг бурхан тэнгэртэй холбон, байгальд захирагдсан байдлаар тайлбарлаж байсан бол тэрээр үүнийг огт өөр өнцгөөс харсан байдаг. Демократын авч үзэж байснаар дайн ба хямрал нь өөрийн гэсэн шалтгаан зүй тогтлоор нөхцөлдөж үүсэн бий болж байдаг байна. Тэрнээс биш дайн хийхэд хүргэж буй далдын таагдашгүй хүчин зүйл гэж байхгүй хэмээн үзсэн байна. Түүний үзэж буйгаар “Дайн ба хямралын үүсэл гарал нь улс орон болон ард түмнүүд харилцан адилгүй эдийн засаг, нийгэм-улс төрийн статусыг олж авсантай холбоотой юм. Ард түмэн ба улс орнуудын харилцан тэнцвэртэй бус байдал нь эхлээд хүмүүс хоорондоо зөрчилдөх улмаар улс орнууд хоорондоо зөрчилдөн дайтахын шалтгаан болдог”¹² байна. Гэхдээ түүний хийсэн дүгнэлтийг хүн төрөлхтний түүх бүхэлдээ батлан харуулж чадахгүй байгаа ч бас түүнийг үгүйсгэх боломжгүй юм. Тиймээс ч өнөөдрийг хүртэл судалгаа шинжилгээний ажилд Демокритын энэ үзэл санаа нөлөөтэй хэвээр байсаар л байгаа юм.

Улс төрийн шинжлэх ухаан дахь хямралын үүсэл гарлыг тайлбарлах судлан тогтоох судалгаа шинжилгээний ажлыг Демокритээс хойш Протагор, Горгий, Алкидамант, Ликофрон, Критий зэрэг философичид хийсэн байдаг. Дээрх философичид хямрал ба дайны тухай, түүний шалтгаан, хүчин зүйлийг судлах явцдаа “Нийгмийн гэрээ”-ний онолын үндсийг тавьсан гэж үздэг. Мөн дээрх философичид “Улс орнууд хямрал ба дайнаас үүсэх хохирлоос ард түмнээ ангид байлгаж гэвэл бие биенээсээ хараат бус байх хэрэгтэй. Харин хараат бус байхын тулд газар нутгаа зааглах хэрэгтэй бөгөөд ард түмнүүдээ тайван найрамдалтай амьдруулахын тулд улс төрийн гэрээг байгуулах зайлшгүй шаардлагатай юм гэж үзээд хямрал ба дайныг дараахь байдлаар томъёолсон байдаг. Үүнд:

- Хүний төрөлх мөн чанар нь эзэрхэг түрэмгий шинж чанартай учраас хямрал ба дайн гэдэг бол хүн төрөлхтний мөнхийн дагуул юм.
- Дайн ба хямралын шалтгаан нь хүчтэй нь хүчгүйгээ засаглах гэсэн хүний далд хүсэл эрмэлзэлтэй холбоотой юм.
- Хямрал ба дайн гэдэг бол хэн нэгэнд гүйцэгдчихвий, хэн нэгнээс хамааралтай болчихвий гэсэн далд айдас дээрээ тулгуурлан үүсдэг ба ийм

¹⁰ Древнекитайская философия. Т1. М. 1994. с.49

¹¹ Книга правителя области Шан. М. 1993. с.183

¹² Разумович Н.П. Политическая и правовая культура Древней Греции. М. 1989. с.70

байдалд орохгүйн тулд бусдыг эрхшээлдээ байлгах гэсэн эзэрхий хүсэл нь ч бас дайныг бий болгодог¹³ гэж тайлбарласан байдаг.

Хямрал ба дайн гэж юу болох түүний үүсэл гарал шалтгааны талаар Сократ дээрх философичидаас ялгаатай хэдэн үзэл санааг дэвшүүлсэн байдаг. Сократын үзэж байснаар улс төрийн хямралын тухай асуудал нь улс төрийн амьдралыг хөндлөнгөөс судлаж байдаг хүмүүсийн хийх ёстой ажил биш харин ч жинхэнэ төрийн удирдлагыг хэрэгжүүлж буй хүмүүсийн мэдэж, эзэмшвэл зохих чадвар байх ёстой гэж үзсэн байдаг. Ийнхүү тэрээр судлаж үзээд улс төрийн засаглалын хямралын доорх шалтгааныг олж тогтоосон байдаг. Үүнд:

- Хүний өөрийнх нь төгс бус байдал
- Нийгмийн амьдралдаа мөрдөж буй хууль эрхзүйн хэм хэмжээний бүтэц ба улс орны хөгжлийн хоорондын үл зохицол
- Хүнд ямагт сайн сайхан зүйлийг насан туршдаа бодож мөрөөдөх боломж хязгаарлагдмал байдаг явдал
- Улс орныг төрийн бодлогоор бус өөрийн хүсэл зоригор удирдахыг эрмэлзэгчид аль ч үед байсаар байдаг явдал юм.

Сократ "Төрд шударгаар үйлчлэн түүнд захирагдай гэвэл хэн ч бай бусдын гэсэн бүхнийг өөрийн болгох гэсэн эрмэлзлэлээ гээх хэрэгтэй юм. Гэтэл өөрийн болгож чадаагүй бусдын эд хөрөнгийг өөрийн юм шиг харж хамгаалж амьдрах тийм хүн байдаггүй"¹⁴ гэж хямрал, зөрчил төрд яагаад байсаар байдгийн шалтгааныг дүгнэн бичсэн байдаг.

Дайн ба хямралын асуудлыг харилцан адилгүй өнцгөөс харж тайлбарласан мэргэдийн тоонд эртний Грекийн нэрт сэтгэгчид болох Платон Аристотель нарыг багтаадаг. Платон дайн ба хямралыг нийгмийн харилцаатай холбон тайлбарлах хандлагыг бүтээсэн. Энэ ойлголтын дор Платон нийгэм болон төрийг удирдах үйл хэргийг багтаан ойлгож байсан. Платон "Төр улс" гэдэг зохиолдоо "Улс орныг удирдана гэдэг нь бүхнийг нэг захиргаанд оруулах урлаг юм"¹⁵ гэж үзсэн. Мөн тэрээр "Нийгэм хөгжих гол хүчин зүйл бол хүчтэй нь хүчгүйгээ захирах явдал юм. Иймээс хямрал ба дайн гэдэг бол хэзээ ч үгүй болохгүй, устаж арилахгүй байнгын үйл явц юм. Тиймээс хямрал хийгээд дайн байсаар л байх болно"¹⁶ гэж үзсэн байдаг.

Мөн Платон төрийн удирдлагын хэлбэр (засаглалын хэлбэр) хэмээх харьцангуй өргөн агуулгатай нэр томъёог авч үзсэн байдаг ба төрийн байгууламжийн нэг хэлбэрээс нөгөө хэлбэрт шилжилтийн шалтгаан нь юу байх гэдэг талаар авч үзсэн байдаг. Тухайлбал түүний үзэж байснаар ардчилал нь хамгийн тогтвор муутай засаглалын хэлбэр учраас эрх чөлөөнд хэтэрхий шунахаас зайлсхийх хэрэгтэй. Засаглалын олигархи хэлбэр нь зэвсэгт хүчний тусламжтайгаар оршин тогтнож байдаг төрийн засаглалын ийм хэлбэрийн үед нийгмийн дээд ба доод ангийн хооронд ашиг сонирхлын нэгдэл бий болдоггүй гэж үзсэн байдаг. Мөн тиран нь "ард түмэн түүний дарамтанд байхгүйн тулд илүү сайн төрийн засаглалын хэлбэрийг эрж хайхад хүргэдэг"¹⁷. Иймээс тиран нь ард түмний дунд үймэн самуун үүсэхэд хүргэдэг учраас төрийн засаглалын туйлын муу хэлбэр юм гэж үзсэн байдаг. Мөн Платон засаглалын ихэнх хэлбэр нь өөрийн гэсэн сул талтай байдаг учраас энэ нь улс төрийн хямрал болон дайн үүсэх шалтгаан болдог гэж

¹³ Разумович Н.П. Политическая и правовая культура Древней Греции. М. 1989. с.75-81

¹⁴ Разумович Н.П. Политическая и правовая культура Древней Греции. М. 1989. с.93

¹⁵ Разумович Н.П. Политическая и правовая культура Древней Греции. М. 1989. с.74

¹⁶ Разумович Н.П. Политическая и правовая культура Древней Греции. М. 1989. с.86

¹⁷ Платон. Сочинения. М., 1972.с.210- 264; 384-385

дүгнэсэн байдаг. Ийнхүү Платон зохиол бүтээлдээ улс төрийн хямрал болон дайны үүсэн бий болох нөхцлийг тайлбарлахдаа нийгэм-улс төрийн хүчин зүйлийг авч үзсэн байна. Улс төрийн нэгдэлийн үндсэн шалтгаан нь нийтийн ашиг тус нийтийн сайн сайхан байдал байх ёстой хэмээн үзсэн байдаг. Иймээс Платон бүлгийн төвшнээс эхлээд төр засаг улс орны хооронд зөрчил үл үйлголцох байдал үүсэхийн гол шалтгаан нь тэдгээр улс төрийн нэгдлийн ашиг сонирхлын үл тохиролцол юм. Энэ үзэл санааг дэвшүүлснээр Платон нь улс төрийн шинжлэх ухаанд нэгэн шинэ судлагдахууныг бий болгосон гэж үздэг.

Эртний Грекийн философич Аристотель улс төрийн хямрал ба дайн, тэдгээрийн шалтгаан үүсэл гарлын талаар өөр хоорондоо харилцан хамааралтай тодорхойлолтыг өгсөн байдаг. Аристотель хямралын нийгэм-улс төрийн хүчин зүйлийг авч үзсэн байдаг ба ингэхдээ "Тооны хувьд нийгмийн олонхи болсон хэсэг нь эрх мэдэлд дурладаг цөөнхөд захирагдаж байдаг төрд дайны шалтгаан байнга байсаар байдаг. Иймээс нийгэмд тэнцвэртэй бус байдал үүсэх нь тодорхой юм. Төрийн засаглалын аристократ хэлбэрийн үед цорын ганц засаглагчийн байр суурь, эрх мэдэл батждаг бол ардчилсан засаглалын үед засаглагчид ба засаглагдагчдын хоорондын харилцаа нь үл биелэх шинж чанартай болдог"¹⁸ гэж үзсэн байдаг.

Төрийн засаглалын нэг хэлбэрээс нөгөө хэлбэрт шилжих явцад Грекийн хот улсуудад тохиолдсон улс төрийн хямралын шалтгааныг Аристотель "Политика" бүтээлдээ дурьдсан байдаг. Түүний бүтээлийн 5-р бүлэг нь бүхэлдээ "төрийн эргэлтийн шалтгаан, төрийн засаглалын хэлбэр бүрийн давуу ба сул тал, төрийн засаглалын хэлбэр бүр бүтцээ хадгалан үлдэхийн тулд ямар арга замыг сонгох хэрэгтэй вэ" гэдгийг судлан тогтооход зориулагдсан байдаг. Аристотелийн үзэж байгаагаар улс оронд тулгарч болох үймээн самуун, гэнэтийн эргэлт, хямралын шалтгаан нь төрийн засаглалын харилцан адилгүй хэлбэрүүдийн дотоод мөн чанартай холбоотой юм.

Эртний Ромийн сэтгэгчдийн төр-эрх зүй, философийн бүтээлд улс төрийн хямрал, дайны шалтгааны талаар үзэл санаа тусгалаа олсон байдаг. Эдгээр сэтгэгчдийн тоонд Гней Флавий, Тиберий Корунканий, Папиниан, Марк Аврелий Антонин нарыг оруулдаг. Марк Тулий Цицерон "Төрийн тухай", "Хуулийн тухай", "Үүрэг хариуцлагын тухай" зэрэг бүтээлдээ улс төрийн хямралын илрэх хэлбэр, шалтгааны тухай авч үзэн Ромийн эзэнт гүрний туулсан түүх, улс төрийн туршлага сургамжтай харьцуулан тайлбарласан байна.

Цицерон төрийн засаглалын хэлбэрийг авч үзээд төрийн засаглалын нэг хэлбэрээс нөгөө хэлбэрт шилжих үйл явцын шалтгааныг олж тогтоосон байдаг. Тэрээр төрийн засаглалын сайн гурван хэлбэрийг тодорхойлоод хаант засаглал оршин тогтнохын тулд удирдлагын үйл явцад арт түмний хүсэл зоригийг авч үздэг байх ёстой гэсэн санааг дэвшүүлсэн байдаг. Мөн тэрээр засаглалын хэлбэр бүрт үймээн самуун, хямралаас зайлсхийх боломж байдаг гэж үзсэн байна. Цицерон бүтээлдээ эрх мэдлийг нэг хүний гарт төвлөрүүлж дарангуйлалд хүргэхгүйн тулд төлөөллийн засаглалыг сонгох нь зохистой арга хэмээн үзсэн байдаг.

Улс төрийн хямралын талаарх шинэ үзэл санааг төлөвшүүлсэн үе бол мэ I зуун болох эртний Христосын шашины хөгжлийн эхэн үе юм. Энэ үеийн төлөөлөгч нь Христийн шашины улс төр эрхзүйн үзэл санааны үндэслэгчдийн нэг, христийн шашны номлогч Аврелийн Августин юм. Түүний улс төр эрхзүйн үзэл санаа нь "Бурханы хотын тухай", "Чөлөөт хүсэл зоригийн тухай" зэрэг бүтээлүүдэд нь тусгалаа олсон байдаг. Тэрээр эдгээр бүтээлүүддээ "Хүн төрөлхтөн бурханд захирагдах ёстой бөгөөд бүхнийг захирах тэр эрдэм чадал бол зөвхөн бурханд

¹⁸ Аристотель. Политика. М. 1911. с.11-13

заяасан байдаг болохоос хүнд тийм билэг авъяас байхгүй юм. Төр улс бол байгалийн шалгарлын үр дүнд л бий болдог учраас бурханы хүсэл зоригоор тухайн улс орныг нэг хэсэг хүмүүс удирдаж, бурханы хүсэл зоригоор бусад хэсэг нь тэдэнд захирагддаг. Тиймээс эрх мэдлээ хадгалан үлдэхийн тулд бурханы хүсэл зоригт үйлчлэх ёстой юм. Мөн засаглалын гол зорилго нь удирдагчид ба удирдуулагчдын хооронд шударга ёсыг тогтоох явдал юм¹⁹ хэмээн үзсэн байдаг.

Августины бүтээлд тусгагдсан гол санаа нь төр ба сүм хийдийн, оюун санааны ба иргэний засаглалын хоорондын харилцааг авч үзсэн явдал юм. Түүний үзэж байснаар иргэний ба шашны засаглал нь харилцан бие биенээсээ үл шалтгаалсан биеэ даасан байдалтай байдаг боловч хямралын үед бие биенээ тэтгэн дэмждэг байх ёстой ажээ. Августины үзэж байснаар төр гэдэг бол сүм хийдийг тэдний дайснаас хамгаалах ёстой институти бол харин сүм хийд нь төр болон шашинд үйлчлэгчдийг хүмүүжүүлдэг газар юм. Эндээс үзэхэд тэр үед шашин, сүм хийдийн засаглал нь бүхнээс дээгүүр тавигдаж байсан байна. Хэдийгээр Августины ертөнцийг үзэх үзэл нь түүний шүтэн биширдэг шашины үзэл номлол дээр тулгуурласан байсан хэдий ч төрийн хямрал түүний үүсэх шалтгааны талаар авч үзэхдээ бурханы хүсэл зоригийн талаар огт авч үзээгүй байдаг. Түүний үзэж байснаар төрийн хямрал үүсэх шалтгаан нь түүний хөгжлийнх дотоод уг сурвалжад байдаг байна.

Улс төрийн хямралын талаар улс төрийн сэтгэлгээний түүхийн эхэн үеийн сэтгэгчид хямралын шалтгаан хүчин зүйлийг түлхүү авч үзэхийн зэрэгцээгээр хямралт нөхцөл байдал, үймээн самууны үед төрийн үүрэг оролцооны талаар авч үзсэн байдаг.

Улс төрийн хямралын шалтгаан хийгээд түүнээс гарах арга замын талаарх Эртний Дорнын (Эртний Энэтхэг) сэтгэгчдийн хувьд үлгэр домгийн шинжтэй байсан бол, Эртний Өрнөдийн (Эртний Грек ба Эртний Ромын) сэтгэгчдийн хувьд илүү бодитой шинжийг агуулсан байдаг байна. Улс төрийн хямрал, түүний шалтгааны тухай эртний сэтгэгчдийн үзэл санаа нь хийсвэрлэлээс онолын чиглэл руу болж өөрчлөгдсөн байдаг гэж үзэж болох юм. Улс төрийн сэтгэлгээний түүхийн хөгжлийн эхэн үед ч улс төрийн хямралын талаар сэтгэгчид үзэж судлан тайлбарлаж байсан нь эндээс харагдаж байна. Улс төрийн хямралын тухай онолын үзэл санааны үндэслэл нь үлгэр домгийн байдлаас онолын шинж хандлагатай болтлоо хөгжсөн энэ байдлаас үзэхэд улс төрийн хямрал хэмээх энэ ойлголт нь их өргөн утга агуулгатай болохыг харуулж байна.

Улс төрийн хямралын талаарх Дундад зууны болон Сэргэн мандалтын үеийн сэтгэгчдийн үзэл баримтлал

Улс төрийн хямралын талаарх онолын үзэл баримтлалд дахин нэг шинэ эргэлт хийсэн үе бол цаг хугацааны хувьд дундад зууны үе бол сэргэн мандалтын үетэй давхцдаг. Энэ үеийн гол үзэл санаа нь улс төрийн хямралыг тайлбарлахдаа нийгэм-улс төр, эдийн засгийн хөгжлийн төвшинтэй холбон авч үзсэн байдаг. Дундад зууныг түүхийн шинжлэх ухаанд дараахь 3 үед хуваан авч үздэг. Үүнд:

1. Түрүү феодалын үе (V-XV зуун хүртэл)- Хэмжээгүй эрхт хаант засаглал задарч, феодалын түрүү үе бүрэлдэн тогтсон

¹⁹ Рыжов О.А. Политико-правовая мысль: история и современность: Учебно-методическое пособие. М, 2005. с.25

2. Феодалын нийгмийн байгууламжын үе (XI-XV зуун хүртэл)- Феодалын нийгмийн байгуулал цэцэглэн хөгжсөн үе
3. Хожуу феодалын үе (XVI-XVII зууны эхэн үе)- Феодалын нийгмийн байгуулал нуран унаж, хөрөнгөтний хувьсгалын эхлэл тавигдсан үе

Феодалыг нийгмийн байгууллын хөгжлийн эхэн үед улс төрийн хямралыг тайлбарлах хандлагад динамик шинж үүссэн ба энэ байдал нь Дундад зуун, Сэргэн мандалтын үе хүртэл хадгалагдсан гэж үздэг.

Константинополь нь 1493 онд Туркэд эзлэгдэх хүртлээ улс төрийн сэтгэлгээний түүхийн төв нь байсан юм. Византын нэрт сэтгэгч Михайл Пселл "Хронография" хэмээх бүтээлдээ улс орныг удирдах элитийн талаар авч үзсэн байдаг. "Төрийг хүнээр төлөөлүүлж үзэх юм бол хүн эд эрхтнээс бүрддэг шиг төрийг удирдагч, түшмэд бүрдүүлдэг. Хүн эрүүл байхын тулд бүх эд эрхтэн нь эрүүл байх учиртай. Тиймээс төр эрүүл байж, үйл ажиллагаагаа хэвийн явуулахын тулд түүний эд эрхтэн болсон албат, түшмэдүүд нь эрүүл саруул ухаантай байх ёстой. Төр улсын хувьд хамгийн хүнд өвчин нь ард түмэн хуулиндаа захирагдахгүй мөн түшмэдийн цэцэн цэлмэг бус ухаанаас шалтгаалан үүсэх эмх журамгүй байдал, үймээн самуун юм"²⁰ хэмээн үзсэн байдаг.

Дундад зууны үеийн Арабын сэтгэгч Ибн Халдун (1332-1406) "Муккадима (Оршил)" хэмээх бүтээлдээ улс төрийн хямралын талаарх үзэл санаагаа тусгасан байдаг. "Улс оронд үүсэх бүхий л өөрчлөлт нь зөвхөн удирдагчтай холбоотойгоор үүсдэггүй бөгөөд удирдуулж байгаа хүмүүстэй ч холбоотой байдаг. Төрийн тогтворгүй байдал ба улс төрийн хямралын шалтгаан нь нэг удам угсааны хаадын хаанчлал тасалдсантай холбоотой"²¹ гэж үзсэн байдаг.

Ибн Халдун улс орны хөгжлийн нэгэн үед тохиолдох үймээн самууны үүсэх шалтгааныг судалж үзээд "Төр оршин байна гэдэг нь түүнийг бүрдүүлэгч ард түмэн тэдэнд үйлчлэгч албатын үйл ажиллагаатай холбоотой ойлголт юм. Тиймээс улс орны цэцэглэн хөгжиж оршин байх нь албат, түшмэдээс шууд шалтгаалдаг. Албат иргэдээсээ шударга байхыг шаардахын тулд төр нь өөрөө шударга байх ёстой. Шудрага байх, улс орон баян байхын үндэс нь мөнгө эд хөрөнгө хэдий ч төрд өөрт нь нийтийн ашиг тусыг эрхэмлэх далд хүсэл эрмэлзэл байх ёстой. Энэ хүсэл эрмэлзэл нь үгүй болоход төрд нь хямрал үүсдэг"²² гэсэн байдаг.

Дундад зууны үеийн Европын сэтгэгчдийн бүтээлд улс төрийн хямралын талаарх үзэл санаа нь ертөнцийг үзэх шашны үзэл дээр суурилсан байдаг. Тэдгээр сэтгэгчдийн нэг нь А. Августин, Аквины Фома нар юм. Аквины Фома хүмүүс хоорондын болон улс хооронд үүсдэг дайн, хямралын шалтгааныг захирах захирагдах харилцааны зөрчилтэй холбон тайлбарласан байдаг. Түүний энэ үзэл санааг Ф.Виктория, Ф. Саурец нар өвлөн авч зохиол бүтээлдээ улам бүр баяжуулсан байдаг. Бурханы хүсэл зоригтой зөрчилдөж нүгэл үйлдсэн хүмүүстэй хариуцлага тооцох явцад сүм хийд ба ард түмний хооронд зөрчил үүсч дайнд хүрч болох талаар авч үзсэн байдаг.

XV зууны Баруун Европт капиталист нийгэм дэх төр болон ард иргэдийн хоорондын харилцаа нь хямралын шалтгаан болж байсан байна. Улс төрийн харилцаанд оролцогч талуудын улс төрийн болон нийгмийн харилцан зөрчилдсөн шинж чанар нь хямралын эсрэг улс төрийн үзэл санааг төлөвшүүлэх зайлшгүй шаардлагыг бий болгосон.

²⁰ Бибииков М.В. Византийская историческая проза. М. 1996. с.25

²¹ Игнатенко А.А. Ибн-Хальдун. М. 1980. с.104-105

²² Игнатенко А.А. Ибн-Хальдун. М. 1980. с.146-147

Италийн нэрт сэтгэгч Н.Макиавелли улс төрийн хямралын талаар дорвитой бүтээл туурвисан эрдэмтний нэг юм. Түүний бүтээлд тусгалаа олсон гол санаа нь : “Төрийн үндэс нь дайны бодлого юм. Дайны бодлого гэдэг нь хямралын эсрэг улс төрийн бодлого бөгөөд дайн зайлшгүй болсон тохиолдолд төр улсаа түүнээс авран хамгаалж авч үлдэх арга хэрэгсэл юм. Дайн гэдэг бол төрийн үйл ажиллагаа зорилгодоо хүрэх нэг арга хэрэгсэл учраас хямралын эсрэг бодлогод төр нь чухал үүрэг гүйцэтгэдэг юм. Иймээс төр ард түмнийхээ өмнө шударга хариуцлагатай байж сурах ёстой юм”.

Макиавелли улс төрийн үймээн самуун, түүнийг шийдвэрлэх арга замыг судлан тогтооход судалгаа шинжилгээний ажлаа зориулсан байдаг учраас түүний бүтээлүүд нь энэ хандлагад чиглэсэн байдаг. Макиавелли улс төрийн хямралыг улс төрийн шинжлэх ухааны зайлшгүй судлан тогтоох ёстой асуудлын нэг гэж үзээд улс төрийн хямралын шалтгааныг улс төрийн зүтгэлтэн, улс төрийн харилцааны субъектийн шинж чанартай холбон авч үзсэн юм.

Дундад зууны үед хямралыг ойлгож тайлбарлах хандлагад зөрчилдсөн шинжтэй байсан ч түүний тайлбарлах шашин ёс суртахууны хандлага нь илүү бодит шинж чанартай болж ирсэн. Харин сэргэн мандалтын үед хямралын талаарх улс төрийн үзэл санаанд дэвшил гараагүйгээр барахгүй бараг зогсонги байдалд орсон гэж үздэг. Ингээд үүний дараагаар улс төрийн хямралын талаарх шинэ үеийн сэтгэгчдийн үзэл санаа бүрэлдэн тогтсон билээ.

XVII зуунд баруун Европт феодализмын эсрэг хөдөлгөөнүүд газар сайгүй өрнөж эхэлснээр шинэ үеийн эхлэл тавигдсан. Эдгээр хувьсгалын үзэл суртлын бэлэг тэмдэг нь кальвинизм байсан хэдий ч нийгмийн амьдралыг зохицуулахад ёс суртахууны эрхзүй ба нийгмийн гэрээний онол чухал хэвээр байсан ажээ.

Хувьсгал өөрөө нийгэм-улс төрийн үзэл санаан дахь хямралын утга агуулгыг тодорхойлох онолыг бий болгохыг шаарддаг байна. Улс төрийн хямралын талаарх анхны онолын чиг хандлагыг тодорхойлох оролдлогыг хийсэн эрдэмтэн бол Нидерландын их сэтгэгч Гуго Гроций юм. Тэрээр “Дайн ба энхийн тухай гурван ном” бүтээлдээ судалгаа шинжилгээний шинэ арга зүй дээр суурилсан дайн ба энхийг судлах улс төр-эрх зүйн хандлагыг тусгасан байдаг.

Гуго Гроций улс төрийн хямралын үүсэх дараахь нөхцлийг судлан тогтоосон байдаг. Үүнд:

- Нэгдүгээрт, хэрвээ нийгмийн амьдралыг зохицуулж буй хууль нь нийгмийн гэрээн дээр тулгуурласан ч бай үгүй ч бай тэр хуулийг өөрчлөх шаардлагыг тавьж болно.
- Хоёрдугаарт, төр нь нийгмийн гэрээг хүчингүй болгосон тохиолдолд улс төрийн хямрал үүсэх шалтгаан болдог гэж үзсэн байдаг.

Мөн Гуго Гроци “Олон улсын харилцаанд үүсэх улс төрийн хямрал үүсэхээс сэргийлэхийн тулд улс орнууд өөр хоорондоо харилцан зөвшилцсөний үндсэн дээр тогтвортой гэрээ байгуулах явдал юм”²³ хэмээн үзсэн байдаг.

Английн философич Томас Гоббс нийгэм-улс төрийн хямралын шалтгааныг байгалиас олж томъёолсон байдаг. Гоббс хүний айдас, олз ашигт шунах түүнд тэмүүлэх хүсэл, аюулгүй амьдарч байгаа эсэхдээ эргэлзэн итгэлгүй байх байдал (орчноос айх айдас), алдар нэрэнд дурлах дотоод хүсэл зориг нь нийгэм-улс төрийн хямрал үүсэх шалтгаан хэмээн тайлбарласан байдаг. Айдас, үл итгэж эргэлзсэн байдал нь хүмүүсийг бие биенийхээ эсрэг дайтахад хүргэдэг гэж үзээд ямар нэгэн удирдлага, засаглалгүй байгалийн шинж төрхөөрөө амьдарч байхад хүмүүст айдас л хургадаг учраас бие биенийхээ эсрэг дайн зарладаг гэж улс төрийн хямрал,

²³ Лейста О.Э. История политических и правовых учений. М, 2000. с.242

түүний шалтгааны талаар үзэл бодлоо илэрхийлсэн байдаг. Мөн бие биенийхээ эсрэг дайсагналцсан байдал хүмүүст хямралт нөхцөл байдлаас хэрхэн гарах арга замыг эрж хайх зайлшгүй шаардлагыг тулгадаг. Хямралаас гарах бичигдсэн арга зам байхгүй хэрнээ нийгмийн амьдралыг жам ёсны эрх зүй зохицуулж байдаг гэж үзсэн байна. Жам ёсны эрх зүй гэдэг нь өөрөө өөрийнхөө бүтцийг хадгалан үлдэх гэсэн эрмэлзэл, харин жам ёсны хууль нь хүнийг өөрийн болоод бусдын амьдралд муугаар нөлөөлөх зүйлийг үйлдэхээс хамгаалах явдал хэмээн Гоббс тайлбар өгсөн байдаг. Жам ёсны хууль нь хүмүүст энэ дэлхий ертөнцийг танин мэдэхийн тулд "юуг хийж болох, юуг хийж болохгүй вэ" гэдгийг ойлгож ухаарах ухаарлыг олгодог гэж тэрээр үзсэн байдаг.

Иргэний дайн, хувьсгал өрнөж байх тэр үед Гоббс улс төрийн үймээн самууны талаар судлахын зэрэгцээгээр хэмжээгүй эрхт хааны эрх мэдлийг хязгаарлах боломжтой парламентын засаглалын талаар судалгааны ажил хийж байсан байна.

Д.Локк хямралын талаар тодорхой үзэл санааг дэвшүүлсэн байдаг. Тэрээр улс төрийн хямралаас сэргэлийлэх нэг боломж нь эрх мэдлийг нэг хүний гарт төвлөрүүлэхгүй түүнийг хувиарлах явдал юм хэмээн үзсэн байдаг. Ж. Локк улс төрийн сэтгэлгээний түүхэнд төрийн дээд эрх мэдлийг хувиарлах зарчмыг тодорхойлсон ба үүгээрээ дамжуулаад тэрээр эрх мэдлийн төвлөрлийг сааруулах боломж бүрдэнэ гэж үзсэн байна. Улмаар эрх мэдлийн төвлөрлийг сааруулснаар улс төрийн хямралаас урьдчилан сэргийлэх боломжтой юм гэж үзсэн байдаг. Төрийн дээд эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглал хэмээн хувиарлаад ингэхдээ засаглалын эдгээр салаа мөчир нь харилцан бие биенийхээ үйл ажиллагаанд оролцохгүйгээр бие биендээ хяналт тавих боломжтой байхаар томъёолсон байдаг. Мөн тэрээр хэрвээ засаглалын дээрх институтуудын аль нэгийг харьцангуй давуу эрхтэй байхаар томъёолбол тэнд хүний эрх эрх чөлөө зөрчигдөж хүн сул дорой байдалд орно хэмээн үзсэн байдаг.

Францын их соён гэгээрүүлэгч, философич Ж.Вольтерын бүтээлд хямралт нөхцөл байдал, хувьсгалын талаарх судалгааны ажил тусгалаа олсон байдаг. Улс төрийн хямрал, хувьсгалын талаарх Ж.Вольтерын үзэл баримтлал нь XVIII зуунд өрнөсөн Францын их хувьсгалын үед бүрэлдэн тогтсон юм. Тиймээс түүний үзэж байснаар нийгэмд үүсэн бий болсон хувьсгал нь аажмаар хямралыг бий болгож энэ нь иргэний дайн болдог хэмээн үзсэн байдаг.

Ш.Л.Монтескье бүтээлдээ төрийн тухай, улс төрийн хямралын тухай авч үзсэн байдаг. Тэрээр улс төрийн систем дэх хямрал, түүний өөрчлөлт, шалтгаан, зүй тогтлыг тогтоох нийгэм-улс төрийн онолын хандлагыг анх бий болгосон юм.

Ш.Монтескьегийн бүтээлд нийгмийн түүхэн хөгжил нь объектив болон субъектив хүчин зүйлээр нөхцөлдсөн байдаг гэж үзээд энэ үйл явцад ард түмний үүрэг оролцоог авч үзсэн байдаг. Өөрөөр хэлбэл нийгэм-улс төрийн системийн хямралын шалтгаан нь түүний өөрийн хөгжлийн зүй тогтлоор нь тодорхойлогддог хэмээн үзсэн байдаг байна.

Ж.Ж.Руссогийн нийгэм-улс төрийн үзэл нь улс төрийн хямралыг тайлбарлахад чухал үүрэг гүйцэтгэдэг улс төрийн радикализмын судалгаанд онолын шинэ хандлагыг бий болгосон байна. Түүний үзлээр хэн хүчтэй тэр нь л нийгэмд засагладаг ба энэ байдлыг нь хууль улам бүр баталгаажуулдаг гэжээ. Тиймээс хэмжээгүй эрхт хаант засаглалыг эсэргүүцэн өрнөж байгаа улс төрийн үйл явц нь түүнийг улам бүр хүчирхэгжүүлсээр байдаг. Хэрвээ ард түмэн дотоод сэтгэлдээ л тэр хэмжээгүй эрхт хаант засаглалыг эсэргүүцсэн хэвээр байх тусам улам бүр дарлагдсаар байх бөгөөд харин хаант төр илүү хүчирхэгжсээр

байдаг. Тиймээс дан ганц оюун санаандаа биш бодит байдал дээр ч түүний эсрэг тэмцэгч байх ёстой хэмээсэн байдаг.

Руссо хүмүүс бие биенийхээ ашиг сонирхлыг харилцан хүлээн зөвшөөрөөгүйн улмаас зөрчилддөг бөгөөд энэ байдал нь улс төрийн хямралын анхдагч шалтгаан болдог гэж үзсэн байна. Нийгмийн гэрээний онолоор хүмүүс харилцан бие биенээ ойлгож хүлээн зөвшөөрч чадсан тохиолдолд удирдлагын төвшинд үүссэн зөрчил, хямралыг шийдвэрлэх боломжтой болно гэж үзсэн байдаг.

Шинэ үеийн нийгэм-улс төрийн сэтгэлгээн дэх улс төрийн хямралыг тайлбарлах онолын хандлагын хөгжлийн оргил үед XIX зууны II хагаст биеэ даасан онол сургааль болтлоо хөгжсөн үзэл баримтлал бол марксизм юм.

К.Маркс, Ф.Энгельс нар хөдөлмөр ба капитал хоёрын хооронд үүсэн нийгэм-эдийн засгийн хямралыг шийдвэрлэх арга зам нь социалист хувьсгалыг ялуулах явдал юм хэмээн үзэж байсан. Капиталист үйлдвэрийн харилцаан дах үйлдвэрлэх хүч ба үйлдвэрийн зогсонги байдлын хооронд үүсэн зөрчилт байдлаас гарах цорын ганц арга зам нь ажилчин ангийг дээдлэх тэднийг дэмжих явдал юм хэмээсэн байдаг. Социалист хувьсгалыг хийх ажилчин анги нь улс төрийн засаглалын төлөөх тэмцэл, улс төрийн намын өрсөлдөөнгүйгээр нийгмийг хөгжил дэвшилд хүргэнэ гэж үзсэн байдаг.

Марксист онол нь ажилчин ангийн үүргийг өндөрт тавьж байсан хэдий ч үйлдвэрлэлийн эдийн засгийн харилцаанд үүсэх нийгэм-эдийн засгийн зөрчлийг шийдвэрлэж үйлдвэрийн хөгжлийг дараагийн шинэ шатанд гаргах арга замыг хайх оролдогыг хийсэн байдаг. Хямрал ба зөрчлийг шийдвэрлэх арга зам нь нийгмийн ноёрхогч ангийг үгүйсгэх түүнийг устгах явдал гэж үзсэн байдаг. Улс төрийн ноёрхогч ангид хямрал ба зөрчлийг ангийн тэмцэлд хүргэдэг гол шалтгаан нь агуулагдаж байдаг учраас тэд л нийгэм-улс төрийн харилцааг зөрчилдсөн байдалд оруулдаг гэж үздэг байна. Иймээс К. Марксын үзэж байгаагаар нийгмийн томоохон бүлгүүдийн зөрчилдөөн нь нийгэмд мөргөлдөөн, хямралыг үүсгэх шалтгаан болдог байна. Анги бүлгүүдийн үзэл бодол, ашиг сонирхлын харилцан зөрчилдсөн байдал нь улс төрийн хямрал, мөргөлдөөний эх үндэс болдог гэсэн макросоциологийн онолын үзэл баримтлалтай агуулгаараа давхцаж байгаа юм. К. Маркс бүтээлдээ "нийгмийн суурь харилцаан дахь эсрэг тэсрэг байдлын тухай хууль"²⁴ гэсэн нэр томъёог шинээр гаргаж ирсэн байдаг.

Улс төрийн хямралыг тайлбарлах ангийн хандлага нь нийгмийн нөөц, баялгийг хуваарилахад дарлагч болон дарлагдагч ангийн хооронд үүсэх тэгш бус байдлаар тодорхойлогддог. Иймээс энэхүү тэгш бус байдлыг арилгахын тулд нийгмийн нөөц баялгийг хуваарилах үйл явцад дарлагдагч ангийн ашиг сонирхлыг түлхүү тусгах хэрэгтэй хэмээн үзсэн байдаг. Нийгмийн шударга бус байдлыг улам бүр гүнзгийрүүлж байдаг объектив хүчин зүйл нь нийгмийн олонхийн хэт туйлширсан хандлагад байдаг гэж үзээд звөхөн дарлагдагч ангийн улс төрийн нэгдэлээр дамжуулан улс төрийн системийг ойлгож тайлбарлах нь дарлагч болон дарлагдагч ангиудын хооронд үүсэх ялгарлыг улам бүр ихэсгэж байдаг гэсэн саналыг дэвшүүлсэн байдаг байна. "Иймээс нийгэм-улс төр эдийн засгийн харилцаан дахь мөлжлөгийн устгаж үгүй хийх нь нийгмийн харилцаанд үүсэх хямралыг шийдвэрлэх арга зам юм"²⁵ гэж К.Маркс үзсэн байдаг байна.

Улс төрийн хямралын үүсэх шалтгаан нь Марксист онолоор бол үйлдвэрлэх хүч ба үйлдвэрлэлийн харилцаан дахь зөрчил юм. Улс төрийн хямралын талаарх энэ хандлагыг баримтлагчид нийгэм бол харилцан зөрчилдсөн бус харин харилцан

²⁴ Коваленко Б.В, Пригов А.И, Рыжов О.А. Политическая конфликтология. М. с.42-43

²⁵ Маркс К. Капитал. Т23. с.761

өөр хоорондоо эв нэгдэлтэй бүлгүүдээс бүрддэг гэж үздэг. Ийм нийгэмд хөгжлийн явцад зөрчил бий болж болох боловч энэ нь харилцан бие биенээ үгүйсгэсэн шинжтэй байх боломжгүй юм гэж үзэж байсан байна. Гэхдээ тухайн үед төр болон нийгэм, коммунист намын өөрийнх нь дотоод нь оршин буй зөрчил, хямрал, мөргөлдөөний эх үндсийг тайлбарлах оролдлого хийгээгүй байдаг. Иймээс ч зөвхөн нийгэмд үзэл суртлын тэнцвэртэй байдлыг бий болгохыг эрмэлзсээр нийгэм-улс төрийн харилцааны гүнд орших хямралын уг сурвалжыг олж хараагүйн нь уг системийн уналтын шалтгаан нь болсон юм.

Улс төрийн хямралын талаарх орчин үеийн онолын чиг хандлагууд

Барууны улс төрийн шинжлэх ухаанд улс төрийн хямралын асуудлыг судлах судалгаа шинжилгээний ажилд өнгөрсөн зууны 60-70аад оны үед шинэ эргэлт бий болж төрийн хямралын талаарх орчин үеийн онолын шинэ чиг хандлагууд олноор бүрэлдэн тогтсон юм.

Энэ үед Л.Биндер, М.Вейнер, М.Пай, С.М.Липсет, Э.Шилз, Д.Лапаламбара нар улс төрийн хямралын талаарх судалгаа шинжилгээний ажлаа хийн бүтээлээ туурвисан байдаг.

Д.Линц, А.Степан, С.Хантингтон, Г.Алмонд, С.Фланаган, Р.Мундт нар ардчилсан дэглэмийн уналтын шалтгааныг хямралын төвшинд нарийн тодорхой судлах оролдогийг хийсэн байдаг. Харин бусад эрдэмтэн судлаачид улс төрийн хямралын талаар ерөнхий судалгааг хийсэн байна. Өнөөдөр улс төрийн хямрал гэж чухам юу болох бусад ийм төрлийн улс төрийн үйл явцаас хэрхэн ялгагдаж байна, нийгэмд ямар хэв шинжтэйгээр илрэн гарч ирдэгийг судлахаасаа илүүтэйгээр илүү прагматик шинж дээр тулгуурлан улс төрийн хямралын менежмент түүнээс сэргийлэх арга замын талаарх судалгаа шинжилгээний ажил давамгайлан хийгдэж байна. Гэсэн хэдий ч орчин үеийн нийгмийн шинжлэх ухаанд улс төрийн хямралын талаар иж бүрэн судалгаа хийгдэж түүнийг тайлбарлах нэгдсэн нэг онол, ойлголт хараахан бий болоогүй байгааг тэмдэглэх нь зүйтэй "Хүн төрөлхтний түүхийн эхэн үеэс өнөөдрийг хүртэл улс төрийн хямралыг тайлбарлах онол, үзэл баримтлал нь үл гүйцэлдэх шинжтэйгээсээ эхлүүлээд түүхэн, газарзүй, системийн хандлагууд бий болж улс төрийн хямралыг тайлбарлах онол хандлагууд түүнийг агуулгыг хувирган өөрчлөөгүйсэн бол энэ ойлголт хүн төрөлхтний мэдлэгийн системд байхгүй байх байсан юм"²⁶.

Глобалчлалын энэ эрин зуунд улс төрийн хямралын талаарх үзэл баримтлалын нэг бүрэлдэхүүн болох аюулгүй байдлын тухай онол гарч ирсэн байна. Аюулгүй байдлыг хангана гэдэг нь хөгжлийн тасралтгүй тогтвортой шинжийг ханган, нийгмийн хөгжлийн үзүүлэлт болох тоо ба чанарын зохистой нэгдлийг хангах тухай ойлголт юм. Нийгмийн аюулгүй байдлын хэв маягууд нь тогтвортой хөгжилд шилжих үйл явц дахь нийгэм улс төрийн системийн хөгжлийн хандлагуудын хэв шинжээр тодорхойлдог. (Жишээ нь: Улс төрийн аюулгүй байдлыг хангахдаа нийгэм эдийн засгийн инновацийг хослуулах гэх мэт). Тэгэхээр нийгмийн хөгжилд дэвшлийг бий болгоно гэдэг нь тухайн дэвшилд тохирсон нийгэм-улс төрийн аюулгүй байдлын төвшинг бий болгоно гэсэн үг юм. Иймээс улс төрийн хямралын төвшинг тодорхойлох энэ аспект нь түүнийг үнэлж дүгнэх нэг аргачлал болохын зэрэгцээгээр нийгмийн хөгжлийг хэв маяг болгон ангилахад зайлшгүй

²⁶ Барсамов В.А. Структура общественно-политического кризиса(теоритический и прикладной анализ).М. 2002. с.7

шаардлагатай нэг үзүүлэлт болох юм. Үүний зэрэгцээгээр энэ нь нэг талаас улс төрийн системийн аюулгүй байдлыг хэрхэн хангасан байна вэ гэдэг үзүүлэлт болно нөгөө талаас нийгмийн тогтвортой бус хөгжлөөс огт өөр шинэ төвшинд шилжих үеийг тодорхойлох нэгэн үзүүлэлт болж байдаг. Тогтвортой хөгжил нь аюулгүй байдлыг зөрчил мөргөлдөөн, зөвшилцөл, хүч хэрэглэх гэх мэт ямар нэгэн аргын тусламжтайгаар хангаж байдаг. Нэг улс үндэстний юмуу аль эсхүл олон улсын төвшин дэх харилцан биенээ үгүйсгэж байгаа харилцаанд аюулгүй байдлыг хангахдаа зөвшилцөх аргыг хэрэглэх, боломжгүй тохиолдолд зөрчил мөргөлдөөний аргыг хэрэглэх гэх мэтээр хангаж байдаг. Аюулгүй байдлыг хангана гэдэг нь хөгжлийн асуудлаас ангид зүйл биш юм. Нийгмийн нэгдэл нягтралыг бий болгосноор аюулгүй байдлыг хангах нь сөрөг харилцаанаас үүсэх үр дагавар, болзошгүй аюулаас тухайн харилцаанд оролцогч талуудыг хамгаалах зорилгоотой байдаг. "Улс төрийн хямралыг тайлбарлах аюулгүй байдлын тухай хандлагын гол санаа нь нийгмийн тогтвортой хөгжлийн аюулгүй байдлыг хангах явдал юм."²⁷

"Улс төрийн хямралыг судлах онол арга зүйн асуудлыг зөвхөн нэг бүтээлээр бүрнээ илэрхийлэх боломжгүй юм. Өөрөөр хэлбэл улс төрийн хямрал гэдэг ойлголт нь зөвхөн нийгэм-улс төрийн салбарын ойлголт биш төдийгүй түүнийг судлан шинжлэх, ангилал ангилал хэв маяг бүхэлдээ нийгмийн бүхий л салбарыг хамарсан байдаг."²⁸

Улс төрийн хямралыг тайлбарлах орчин үеийн циклийн хандлага нь Ибн Халдуны үзэл баримтлалаас эхтэй юм. Уг онолын энэ хандлагын гол утга санаа нь улс төрийн хямралын мөчлөгийг тогтоох гэсэн оролдлого юм. Улс төрийн хямралын шалтгаан нь нийгмийн хөгжлийн мөчлөгтэй хамаатай юм. Мөчлөг гэдэг нь улс төрийн хямралыг тайлбарлах нэг арга төдийгүй хэлбэр юм. Улс төрийн хямралыг судлах мөчлөгийн арга аргазүй нь хүн төрөлхтний түүхэнд олон удаа хэрэглэгдсэн байдаг. Нийгмийн хөгжлийн нэгэн үеийн илрэл болох улс төрийн хямралын судлах мөчлөгийн судалгааны арга зүй нь нийгмийн зогсонги байдалд юм уу аль эсвэл нийгмийн эрс шинэчлэл, бүр сүйрлийн үед ч нийгмийн цаашдын төлөв байдлыг урьдчилан таамаглах аргачлал болж байдаг.

А.Тойнби, О.Шпенглер нар хүн төрөлхтний нийгмийн хөгжлийн явцад үүсэн бий болсон соёл иргэншлүүд нь үүсэл, өсөлт, хувиралт өөрчлөлт, задрал, сүйрэл гэсэн таван шатыг дамждаг гэж үзсэн байдаг. А.Тойнби түүхийн тодорхой нэг цаг үе дэх соёл иргэншлийн хөгжлийн үйл явцыг авч үзээд иргэншлийн хөгжлийн янз бүрийн үеүдэд үүсч болох улс төрийн хямралын хэлбэрүүдийг тодорхойлсон байдаг. Мөн тухайн шатан дахь соёл иргэншлэл нь өөрөө хямарч устаж үгүй болох боломжтой гэж үзсэн байна. Улс орон дахь төр засгийн хямрал нь гүнзгийрээд ирэхээр түүний шалтгаан нь улс төрийн гэдгээсээ илүү соёл иргэншлийн асуудалтай холбоотой болж хувирдаг гэж үзсэн байдаг.

А.Тойнбийн бүтээлийг өнгөцхөн харахад улс төрийн хямралын талаар харьцангуй бага судалгаа хийсэн юм шиг харагддаг ч төрийн тусгаар тогтносон байдлын хямрал ба соёл иргэншлийн хямралын хоорондын хамаарлыг тодорхойлох оролдлогыг хийсэн нь улс төрийн хямрал судлалын салбарт томоохон дэвшил болсон юм. "Үймээн самууны дараа уналтанд орсон төр засгийг сэргээн тусгаар тогтносон улсыг бүтээнэ гэдэг нь удтал хүлээсэн намрын шар нар орчлон дэлхийг гийгүүлэхтэй адил юм"²⁹ гэж А.Тойнби бүтээлдээ тэмдэглэсэн байдаг.

²⁷ Рогозян О.В. Политический кризис: анализ и технологии. М. 2006. с.60-62

²⁸ Барсамов В.А. Политический кризис и смуты(история, теория и современность). М. 1996. с.15-25

²⁹ Тойнби А. Постигение историй. М. 1991. с.453

Улс төрийн хямралыг тайлбарлах судлах модернизацийн хандлага нь уламжлалт нийгмийн байгууллаас аж үйлдвэржсэн нийгэмд шилжих шилжилтийн үеийн нийгмийн хөгжлийн байнгын дэвшин өөрчлөгдөж байгаа тэр үйл явцаас үүсэлтэй юм.

Энэ шилжилтийн үйл явцад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг үндэстний төр нь нийгмийг модернизачлах үйл явцад хямралыг үүсгэж байдаг. Нийгмийг модернизачлах процессыг эргэлт буцалтгүйгээр сонгосон улсуудын хувьд нийгэм-улс төрийн системдээ өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай тулгардаг. Харин өөрчлөлт хийх энэ үйл явц нь ямар нэгэн байдлаар хямралт шинжийг агуулж байдаг учраас өөрчлөлт нь хямралыг үүсгэж болзошгүй юм.

Модернизацийн эхэн үед шилжилтийн эдийн засаг нь нэг хэлбэрээс нөгөө хэлбэрт шилждэг байна. Гэтэл өнгөрсөр зууны 60-аад онд модернизацийн процесс нь зөвхөн нийгмийн хуучин институтуудыг өөрчлөх үйл явцаар хязгаарлагдсан байсан байдаг. Модернизацийн хоёрдугаар шатанд нийгмийг бүрдүүлж байгаа дэд системүүд нь бие биентэйгээ тохирохоо больж улмаар нэгдэн нягтрахаасаа илүүтэйгээр заагран ялгарч эхэлдэг.

Модернизацийн гол агуулга нь нэг нийгмийн байгууллыг нөгөө нийгмийн байгууллаар солихдоо нийгмийг шилжилтийн арга замаар өөрчлөхийг оролддог. Ийм үед нийгэмд өрнөж байгаа өөрчлөлт, эдийн засгийн шилжилтийн үйл явцыг даван туулахад төрийн хяналт, үүрэг оролцоо зайлшгүй чухал байдаг.

Улс төрийн хямралыг тайлбарлах бүтэц-үүргийн хандлага нь нийгэм улс төрийн янз бүрийн систем дэх түүнийг бүрдүүлэгч элементүүдийн гүйцэтгэх үүрэг эсхэл үүргээ алдсанаар бүтэц үл оршин тогтнох үйл явцыг авч үздэг. Засаглалын хүлээн зөвшөөрөгдсөн байдлын хямрал, оролцооны ба мөргөлдөөнийг шийдвэрлэх арга барилын хямрал зэргийг энэ хандлагын үүднээс тайлбарладаг байна.

Засаглалын хүлээн зөвшөөрөгдсөн байдлын хямрал гэдэг нь нийгмийн удирдлага ба олон түмэн нь улс төрийн эрх мэдэл бүхий элитүүдийг хүлээн зөвшөөрөхгүй тэдэнд итгэл үзлэхгүй байгаатай холбогдон бий болж байдаг. Удирдагч элит нь улс төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх боломжийг хуулиар олж авдаг ба тэрхүү хууль нь улс төрийн засаглалыг хэрэгжүүлэх боломжийг эрхзүйн хувьд баталгаажуулж өгдөг байна. Иймээс засаглагч элит ба засаглагдагч ард түмэн хоёрын хооронд харилцан биенээ үл хүлээн зөвшөөрсөн байдал үүсэх нь удирдлагыг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлдөг байна. Иймээс нийгмийг удирдагч элитүүд нь засаглалаа хуулиар хүлээн зөвшөөрүүлж чаддаг ч олон түмэн тэд нарт захирагдахаас илүү эрх чөлөөтэй байхыг эрхэмлэснээр тэдний хооронд хямрал үүсдэг байна.

Улс төрийн хямралыг тайлбарлах "Хувьсгалын хандлага"³⁰ нь хүн төрөлхтний түүхэнд сүүлийн зуун жилийн хугацаанд өрнөсөн хувьсгалын үйл явц дээр суурилсан гэж үздэг. Дэлхий ертөнц социализм, капитализм гэсэн хоёр системд хуваагдсанаар хувьсгалыг тайлбарлах дараахь хоёр өөр үзэл сурталын хандлага нэгэн зэрэг бий болсон байна.

Нэгдүгээр хандлагаар хувьсгал гэдэг нь нийгмийн хөгжлийн хууль болон олон түмний хүчийг ашиглан түүхийг өөрчлөх үйл явц юм гэж үздэг байна.

Хувьсгалыг тайлбарлах хоёр дахь хандлагаар хувьсгал нь нийгмийн хөгжлийг сааруулан түүнд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйл юм гэж үздэг байна. Эхний хандлага нь хувьсгалын улс төр, үзэл суртлын үүргийг чухалчилсан бол хоёр дахь хандлага нь хувьсгалын явцад үүсэх сөрөг үр дагаврыг нь илүү чухалчлан авч үзсэн байдаг.

³⁰Барсамов В.А. Цветные революции: теоритический прикладной аспекты. //Социологические исследования. 2006. №8. с.57-66

Нэгдүгээр хандлага нь хувьсгалыг тайлбарлах нийгмийн хувьсгалын нэг биеэ даасан хэлбэр болсон лениний загвар дээр суурилсан байдаг. Энэ хандлагыг практик ач холбогдол талаас нь авч үзвэл зөвхөн ажилчин ангийн хувьд онцгой ач холбогдолтой байсан төдийгүй улс төрийн системийн хувьд хаалттай, хагас хаалттай аль ч улс орнуудын хувьд нийгмийн амьдралынх нь нэгэн хэв маяг болсон байсан юм. Уг хандлагыг тодорхойлох нэг хүчин зүйл бол цэрэг, армийг хувьсгал хийхэд чухал үүрэгтэйгээр оролцдог намын нэг хэлбэр мэтээр авч үзсэн байдаг оршиж байгаа юм. Социалист систем бүхий улс орнуудад улс төрийн үзэл суртлын үүргийг гүйцэтгэж байсан социалист үзэл санаа нь нийгмийн гишүүдийн нийтээрээ хүлээн зөвшөөрөгдсөн үзэл суртал төдийгүй улс төрийн хүчний хувьд ч гүн шингэсэн үзэл баримтлал нь байсан юм. Жишээ нь үндэсний эрх чөлөөний хувьсгал гэх энэ загвар нь ангийн хувьсгал гэдэг нэр томъёотой салшгүй холбоотойгоор судлагдсаар ирсэн байдаг. Ихэнх улс оронд улс төрийн бүлэглэлүүд нь хувьсгалын энэ загвараар хувьсгалыг амжилттай зохион байгуулсан түүх байдаг.

Хувьсгалын энэ загварыг магтан сайшаах нэг хэсэг байхад нөгөө нэг хэсэг нь түүний сөрөг муу талыг авч үзэх нь бий. Хувьсгалын хөдөлгөх хүч болох ажилчин, тариачин ангийн улс төрийн үзэл суртлын үндэс суурийн талаар авч үзэж байсан боловч хувьсгал хийх зайлшгүй шалтгаан нөхцлийн талаар сайтар авч үзээгүй байсан.

Хоёрдугаар хандлага нь нийгмийн тогтвортой байдлыг ганхуулахад хүргэдэг хувьсгалыг аядуу зөөлөн замаар явуулах аль эсвэл түүнийг бүр хийхгүй байсан нь дээр гэсэн хувьсгалын эсрэг үзэл санаан дээр суурилсан байдаг. Иймээс энэ хандлагыг хувьсгалыг тайлбарлах хүчирхийллийн бус аядуу хандлага хэмээн авч үздэг.

Өнгөрсөн зууны 70-80-аад онуудад нийгэмд тогтвортой байдлыг аядуу, хүчирхийллийн бус зөөлөн аргаар бий болгох олон тооны судалгаа шинжилгээний ажил хийгдсэн байдгийг дурьдах зүйтэй юм.

Хувьсгалын талаар судалгаа хийсэн барууны зарим судлаачдын бүтээлээс үзэхэд хувьсгалын талаарх онолын хөгжилд дөрвөн том үеийг бий болгосон байдаг.

Нэгдүгээр үе нь хувьсгалын зөвхөн үүсэн бий болох шалтгаан, хувьсгалын тохирооны талаар судалгаа хийсэн байдаг.

Хоёрдугаар үед хувьсгалын талаарх онолын чиг хандлагуудыг бий болгож, улмаар хямралын дотоод болон гадаад хүчин зүйл, харилцан зөрчилдсөн байдалд анхаарлаа хандуулж хувьсгалын практик болон онолын ач холбогдлыг тодорхойлсон байдаг.

Гуравдугаар үед буюу XX зууны 70-80-аад онуудад нийгмийн улс төр, эдийн засгийн системд сөргөөр нөлөөлж, түүний хөгжлийг сааруулж байдаг хувьсгалын хүчин зүйлийн талаар судалгаа хийн хувьсгал хийхэд зайлшгүй шаардлагатай хүчин зүйл юу болох талаар хэлэлцсэн байдаг.

Дөрөвдүгээр үе нь хувьсгалын хүчин зүйлийг судлахдаа системтэйгээр харьцуулан судлах онолын шинэ чиг хандлагууд бий болгосон байдаг. Мөн хувьсгалыг хийснээр нийгэмд тогтвортой, тогтвортой бус байдлын аль нь үүсэх нь тухайн хувьсгалын анхдагч шалтгаан юу байсан гэдгээс шууд хамаардаг хэмээн үзсэн байдаг.

Өнөөдөр хувьсгалыг тайлбарлах субъектив, марксист-ленинист, бүтэц-үүргийн, элитийн, нийгэм-сэтгэлзүйн гэх мэт олон хандлагууд байсаар байгаа хэдий ч үүнтэй зэрэгцэн орчин үед хувьсгал хэмээх энэ нэр томъёог тайлбарлах олон шинэ хүчин зүйлүүд бий болсоор байна.

Улс төрийн хямралын тайлбарлах системийн хандлага нь зөвхөн системийн элементийн хямралын талаар биш харин системийн зорилгодоо хүрэх явц дах

элементүүдийн харилцан үйлчилсэний нөлөөгөөр үүсэх хямралын талаар тодорхой авч үзсэн байдаг.

Дүгнэлт

Улс төрийн хямралын тухай үзэл санаа хэрхэн бүрэлдэн тогтсон үйл явцыг улс төрийн сэтгэлгээний дараахь дөрвөн үеийн хүрээнд авч үзсэн болно.

Нэгдүгээр үе- Эртний сэтгэгчдийн үзэл санаан дах улс төрийн хямралын тухай ойлголтын түүхийг авч үзсэн. Энэ үед улс төрийн хямрал, улс төрийн үймээн самуун бүхий байдлын шалтгаан, түүнээс гарах арга замыг бурхан тэнгэртэй холбон ойлгох шашин, домгийн хандлага давамгайлж байсан хэдий ч улс төрийн хямрал үүсэхэд тухайн улсыг хаанчилж байгаа хааны төрийг удирдах удирдлагатай холбоотой гэсэн санаа байсныг дурьдах нь зүйтэй юм.

Хоёрдугаар үе- Дундад зууны ба Сэргэн мандалтын үеийн сэтгэгчдийн бүтээлд улс төрийн хямралын тухай үзэл санаа хэрхэн тусгагдсан талаар авч үзсэн болно. Энэ үед улс төрийн хямралын тухай домгийн үзэл санаа нь улс төрийн бодит үзэл санаагаар солигдох эхлэл тавигдсан хэдий ч улс төрийн хямралд хандах хандлага сөрөг хэвээр байсан юм.

Гуравдугаар үе- Энэ үе нь улс төрийн хямралын тухай орчин үеийн онолын хандлага төлөвшихөд чухлаар нөлөөлсөн шинэ үеийг төлөөлж байгаа юм.

Дөрөвдүгээр үе- Улс төрийн хямралын талаарх орчин үеийн үзэл баримтлалын агуулгыг авч үзсэн болно.

Энэ мэтээр нийгмийн улс төрийн амьдрал дах хямралыг тайлбарлах олон хандлага байгаа боловч улс төрийн хямралыг ойлгож тайлбарлах нэгдсэн нэг онолын хандлага хараахан байхгүй байгаа юм.

Резюме

При выполнении научной задачи периодизации генезиса и эволюции теории политических кризисов, опираясь на исторический (хронологический) подход, были выделены четыре основных периода.

Первый период — развитие представлений о политических кризисных явлениях мыслителей Древнего мира.

Второй период — формирование взглядов на проблему политических кризисов ученых Средневековья и Возрождения, которые носили крайне противоречивый характер, что обуславливалось засильем теологического подхода к осмыслению политических реалий.

Третий период — выделение кризисного направления в общественно-политической мысли Нового времени способствовало зарождению научных основ современных теоретических подходов к проблеме политических кризисов;

Четвертый период — разработка современных концепций политических кризисов.

Генезис и эволюция взглядов, идей и концепций политических кризисов мыслителей, ученых выделены в отдельное направление проводимого исследования за рамками общей периодизации. Это аргументируется результатами анализа, позволяющими сделать вывод об особом вкладе наших соотечественников в разработку кризисной проблематики, в том числе и в политической сфере жизни отечественного социума.

Ном зүй

1. *Аристотель*. Сочинения в 4 тт. М., 1976
2. *Артхашастра*. М. Наука, 1993
3. *Барсамов В.А.* Политические кризисы и смуты (История, теория, современность). М., 1996.
4. *Барсамов В.А.* Структура общественно-политического кризиса (теоретический и прикладной анализ). М., 2002.
5. *Брега А.В.* Политический риск в обеспечении военной безопасности: Монография. — М.: ВУ, 2007.
6. *Бибилов М.В.* Византийская историческая проза. М., 1996
7. *Богданов А.А.* Тектология. Всеобщая организационная наука. М., 1989.
8. *Делягин М.Г.* Мировой кризис: Общая теория глобализации: М., 2003.
9. *Древнекитайская философия*. М., 1994
10. *Ибн-Халдун*. Избранные произведения мыслителей стран Ближнего и Среднего Востока. М., 1961.
11. *Игнатенко А.А.* Ибн-Хальдун. М. Мысль 1980.
12. История политических и правовых учений. Древний мир. М. Наука. 1985.
13. История политических и правовых учений./ Под редакцией О. Э. Лейста. М., 2000.
14. Книга правителя области Шан. М. Наука. 1993..
15. *Левинтов Н.Г.* Теоретически-методологический аспект проблемы общенационального кризиса. Ульяновск. 1980.
16. *Матвеев Р.Ф.* Общая теория политических кризисов. Аналитическая политология. М., 1997
17. *Платон*. Сочинения. - М.: Наука, 1972.
18. Политическая энциклопедия: В 2 т. М.: Мысль, 1999.